

**МАНДАЛ ДААТГАЛ ХК-НИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛЫН ТӨСӨЛ**

**Гүйцэтгэх захирлыг чөлөөлж,
үүрэг гүйцэтгэгч томилох тухай**

Компаний тухай хуулийн 76.1.8, 76.1.9 болон Компанийн дүрмийн 18.13.7, 8.13.8, 12.7-р заалт болон 2021 оны 10 сарын 01-ны өдрийн “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирал Батсайхан овогтой Жавхлан нь өөр албан тушаалд шилжин ажиллах болсон тул 2021 оны 10 сарын 01-ны өдрөөс эхлэн “Мандал Даатгал” ХК-ны гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэхүү шийдвэртэй холбогдуулан “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Чүлтэм овогтой Даваадашийг томилсугай.

3. “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлыг чөлөөлж, үүрэг гүйцэтгэгч томилсонтой холбогдуулан ажил хүлээлцэх комисс байгуулж, тус комиссын гишүүнээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх Цалин урамшууллын хорооны гишүүдийг томилсугай.

4. Хөдөлмөрийн тухай хууль болон тус Компанийн дүрэмд нийцүүлэн “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон Ч.Даваадаштай хөдөлмөрийн гэрээ байгуулсугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор хууль болон журамд заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооноос тохиромжтой этгээдийн талаар дүгнэлт гаргуулах, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч томилогдсон талаар хамтран ажилладаг байгууллагуудад албан бичиг хүргүүлж, нийтэд нээлттэй мэдээллэх ажлыг зохион байгуулахыг “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ч.Даваадашид даалгасугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшинд даалгасугай.

Энэхүү шийдвэрийг 2021 оны 10 сарын 01-ны өдөр бичгээр үйлдсэнийг гэрчлэн компаний тухай хуулийн 80.2-р заалтыг үндэслэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ